МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2017 оны 02 сарын 16 өдөр Дугаар 18 Улаанбаатар хот

Инновацийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос томилогдсон ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг.Мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд бий болсон шинэ санаа, өндөр технологийг эдийн засгийн эргэлтэд оруулах, үндэсний инновацийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай:

Хоёр.Инновацийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

1/Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогыг 2017 оны 2 дугаар улиралд багтаан батлан хэрэгжүүлж эхлэх;

2/Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг судлан боловсруулж, хуулийн төслийг Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулганы хугацаанд өргөн барих;

3/Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, 2018 оны 2 дугаар улиралд багтаан батлан, хэрэгжүүлж эхлэх;

4/Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, "инновацийн сан"-г байгуулах, инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, венч хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээг 2017 оны 4 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлэх.

Гурав.Өндөр технологи болон гарааны компани, гарааны бизнесийг дэмжиж өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, инновацийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд гаргах, нөхцөл боломжийг хангах чиглэлээр:

1/хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг инновацийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, дэмжлэг үзүүлэх, хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх;

2/Инновацийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах, эрдэм шинжилгээний

байгууллага, аж ахуйн нэгжийн хэрэгжүүлж буй инновацийн төсөл, бүтээгдэхүүнийг дэмжих зохицуулалт хийх;

3/Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг импортоор оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас, дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4/Инновацийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалтын хэрэгжилтийг хангах, дотоодод үйлдвэрлэж буй инновацийн бүтээгдэхүүнийг борлуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх, худалдан авалтаар дэмжих;

5/инновацийн дэд бүтцийг сайжруулах, бэхжүүлэхэд төрөөс санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх, технологи дамжуулах төв, технологийн инкубатор байгуулж, технологи бойжуулах, туршин нэвтрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх;

6/судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, үйлдвэрлэлийн технологийг сайжруулах зорилго бүхий технологийн бирж бий болгон ажиллуулах;

7/Инновацийн тухай хуулийг дагалдаж гарсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дөрөв.Инновацийн үйл ажиллагааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, олон нийтийг соён гэрээрүүлэх арга хэмжээ авч, холбогдох санхүүжилтийг төрөөс шийдвэрлэн хэрэгжүүлэх.

Тав.Төр, шинжлэх ухаан, бизнесийн байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлж, төрийн бодлого, шийдвэрийн төсөл боловсруулахад холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын санал, дүгнэлт, зөвлөмжийг харгалзаж байх.

Зургаа.Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Шинжлэх ухааны паркийн захиргааны бэлтгэл ажлыг эрчимжүүлэх, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх.

Долоо.Инновацийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг бодлогоор дэмжиж чадавхжуулах, технологийн болон

оюуны өмчийн үнэлгээ хийх, технологи дамжуулалтын болон лицензийн гэрээ хийх журмыг боловсруулан мөрдүүлэх.

Найм.Энэ тогтоолд заасан асуудлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж, ээлж дараатай хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд тайлагнаж байхыг Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт үүрэг болгосугай.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Л.ЭНХТАМГАЛАН